

“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

| БУЛГАН АЙМГИЙН МУЗЕЙ | | | | | | | | |
|-----------------------------|---------------------------------------|---------------|------------|---|--------------------------------|---|---|----------------|
| Д/д | Үзмэрийн нэр | Хувийн дугаар | Тоо ширхэг | Хэмжээ | УБМС-ийн дугаар РСН (проаммын) | Судлагдсан сурталчлагдсан байдал | Саналын үндэслэл | СӨҮТ-ийн санал |
| 1 | Хэт хутга | 69.02.1-9 | 9 | Хутга урт-30 см Хутганы хуй -26,7 см Савх 2 ширхэг урт -31,3 см Гинж богино - 26 см Гинж урт -71 см Хэт - өн- 6.6 см, өр-8.3 см Нийт жин - 1.412 гр | 6301БУМ01280 | Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис. Ц.Цэндсүрэн нар. 2014. | Түшээт хан Дашням нь 26 настайдаа Богд Хаант Монгол Улсыг байгуулахад алтан урагийн ноёдыг оройлон оролцсон ба 1912 онд Тусгаар тогтнолын үйл хэрэгт оролцсон эрэлхэг эх орончдоос хамгийн түрүүнд Дашням ханыг онилон хорлосон байдаг. Уг хүний эдэлж хэрэглэж байсан XIX-XX зууны үед Монгол дархны дахин давтагдашгүй аргаар урласан бөгөөд маш нарийн ур хийцтэй, гоёл чимэглэл болон хэрэглээний эд зүйл болох хоолны савх, хэт зэрэг иж бүрэн үнэт металл болох мөнгөн тоногтой, 4 шүрэн, 2 оюу шигтгээтэй хэт хутга нь тус музейн нандин үзмэрүүдийн нэг билээ. Уг үзмэрийг Аймгийн музейн сан хөмрөгт 1968 оны үзмэр цуглуулгаар Гурван булаг сумын иргэн Тарваас авсан. | Дэмжсэн |
| 2 | Ардын Хатанбаатар Магсаржавын хантааз | 54.08 | 1 | Урт-92 см, өргөн-63 см, жин-22.5 гр | 6301БУМ00814 | Доктор Г.Мягмарсамбуу судалж шинжлэх ухааны эргэлтэд оруулсан. Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис. Ц.Цэндсүрэн нар. 2014. “Музейн мэдээлэл” сэтгүүл. Ж.Ганбат. 2012. | XX зууны төр цэргийн нэрт зүтгэлтэн, цэргийн жанжин Цэргийн явдлын яамны сайд ардын хатанбаатар Магсаржавын алдар гавьяаг нь мөнхжүүлэх зорилгоор Булган аймгийн төв дуулгат бунханыг байгуулж шарилыг нь шилжүүлэн | Дэмжсэн |

| | | | | | | | | |
|---|-------------------------|-------|---|---|--------------|---|--|---------|
| | | | | | | <p>бунхалсан байна.1998 онд Монгол Улсын Засгийн Газрын 39 дүгээр тогтоолоор Булган аймгийн Хутаг-Өндөр сумын дунд сургуулийг Ардын Хатанбаатар С. Магсаржавын нэрэмжит сургууль болгосон.</p> <p>Түүний энэхүү хантаазыг Улаан хүрэн чисчүү, торго түүнийг улбар шар өнгийн цулгуй, чисчүүгээр давхар эмжиж, булан бүрийг хагас өлзий хээгээр чимэглэжээ. Уг үзмэрийг Аймгийн музейн сан хөмрөгт 1983 оны үзмэр цуглуулгаар иргэн охин Ичинхорлоогоос авсан.</p> | | |
| 3 | Ш.Намхай аваргын хөөрөг | 73.02 | 1 | Өн-10.5см, өр-4.6 см, жин-85 гр Амсарын диаметр-1.5см | | <p>Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис. Ц.Цэндсүрэн нар. 2014.</p> | <p>Наадамд түрүүлэхэд нь Гадаад хэргийн анхны сайд Эрдэнэ дайчин хошой чин ван М.Ханддорж Даншигийн их аварга Ш.Намхайг 1908 онд Чүлтэм аваргыг орхин наадамд түрүүлэхэд нь Бээжингээс захиалан авчирч гардуулсан байна. . XX зууны эхэн үед бүтээгдэн, хэрэглэж байсан хув толгойтой, гуулин нуухтай, төмөр халбагатай хятад эрээн шаазан хөөрөг, ёроол дээрээ хятад ханз бичигтэй.Уг үзмэрийг Аймгийн музейн сан хөмрөгт 1973 оны үзмэр цуглуулгаар иргэн Доржоос авсан.</p> | Дэмжсэн |
| 4 | Солир | 72.03 | 1 | Жин нь 13.735гр, өн-13 см, өр-21см, урт-23см, зузаан- | 6301БУМ01392 | <p>“Булган аймгийн музейн олдвор “солир” гэх хайлшийн химийн судалгаа ба үнэлгээ” Ж.Оюун, Ч.Наранчимэг. 2016.</p> | <p>Агаарт бүрмөсөн шатаж дуусалгүй дэлхийн гадарга дээр унах сансрын биет бөгөөд нарны аймгийн бүрэлдэхүүнд багтдаг хатуу бодис. Найрлагаар нь: Чулуун, Төмрөн, Төмрөн чулуун</p> | Дэмжсэн |

| | | | | | | | | |
|--------------------------------|--|--|--|----------------------|--|--|---|--|
| | | | | 20.2, голч-85 см. | | | гэж ангилдаг. Булган аймгийн Орхон суманд 1970 онд унасан. | |
| НИЙТ 4 ДЭСИЙН 12 ШИРХЭГ | | | | | | | | |